

Галын аюулгүй байдлын талаарх зөвлөмж



Галын аюулгүй  
байдлын талаарх  
**ЗӨВЛӨМЖ**

Fire safety behavior tips



## Галын аюулгүй байдлын тухай

### ! Заавал мэдэж байх ёстой зүйлс

- ✓ Галын хороо харагдахуйц газар байрлуулж ашиглах аргыг нь мэдэж байх
- ✓ Аварын гарцын замыг хааж эд зүйлс тавихгүй байх

### Өрхийн хэмжээнд гал түймрээс урьдчилан сэргийлэх

- Галаар тоглохгүй байх.
- Галын хорыг ил харагдахуйц газар байрлуулж хэрэглэх зааврыг мэдэж байх.
- Утаа мэдрэгчийг өрөө болгонд суурилуулах, ажиллаж буй эсэхийн байнга шалгах.
- Цахилгаан барааг стандартын дагуу ашиглаж нэг залгуурт нэг хэрэглэгч залгах, давхар холболт хийхгүй байх, халж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих
- Газ(шингэн хий)ныхаа хавхалгыг байнга хаах, сард 1удаа газнаас хий алдаж буйг шалгаж байх.
- Тагтанд гаргасан аюулгүйн гарц(нимгэн хана)-ыг энгийн үе ч гэсэн хааж эд зүйлс тавихгүй байх.




### Tip!

### Урьдчилан мэдэж байх ёстой зүйлс

- Гадагш гарах арга ба гараад цугларах газраа урьдчилан товлох.
- Гадагш гарахдаа авч гарах хэрэгтэй эд зүйлсийн жагсаалтыг гаргаж, тэдгээрийг авч гарах хүнээ товлох.
- Яаралтай үед холбогдож болох ойрын хүний холбогдох утасны дугаарыг бэлдэх.
- Хаалганы завсарыг давуун скокч(ногоон) эсвэл алчуураар чигжиж битүүлэх.
- Гадагш гарах үед нойтон алчуур болон хэрэгтэй зүйлсийг бэлдэх.
- Яаралтай гарах явцад гараад уулзах газар болон холбоо барих аргаа товлох
- Дээврийн хаалга нээлттэй эсэхийг байнга шалгах, хаалганы нээлт(хаалт)-ийн автомат систем ажиллаж байгаа эсэхийг шалгах.
- Өрөөний хаалгыг хаавал гал болон утааны тархацыг удаашруулах боломжтой.

### Галын аюулаас дүрвэн гадагш гарах Галын дохиолол дугарах үед



### 1 Яаралтай арга хэмжээ авах

- Унтаж байх үед галын дохиолол дугарвал гал гарсан эсэхийг шалгах гэж цаг алдалгүйгээр бусад бүх хүнэ сэрээж нэг дор цугларан зааврын дагуу аюулгүй газарлуу дүрвэн гарна.

### 2 Дүрвэх аргаа урьдчилан товлох

- Хаалганы бариулд гарын ар талаар хүрч халсан эсэхийг шалгана. Халуун байвал хаалгыг нээж болохгүй цаана нь гал гарч байна гэсэн үг.
- Өрөөнд утаа орж ирж буй тал болон хаалганы бариул халсан эсэхийг шалгаж хаалгаар гарах уу цонхоор гарах уу гэдгээ шийднэ.

### 3 Шуурхай дүрвэх арга хэмжээ авах

- Гал гарсан үед ямар ч тохиолдолд цахилгаан шат хэрэглэж болохгүй. Зөвхөн шат ашиглах буух хэрэгтэй.

### 4 119 дугаарт дуудлага өгөх

- Гадагш гармагц 119 дугаарт дуудлага өгөх.
- Таны биед утас байгаа тохиолдолд 119 дугаарт дуудлага өгч болох боловч дуудлага өгөх гэж байна гээд гадагш гарах цагаа алдаж болохгүй.

### 5 Гадагшаа гармагц хүнээ бүртгэх

- Хүүхдийн тоглоомын талбай зэрэг урьдчилан болзсон газраа цуглаад хүнээ бүртгэнэ.
- Харагдахгүй байгаа бусад бүх хүнээ гал сөнөөгчид яаралтай мэдэгдэх

**Галын аюулаас дүрвэн гарах Гал гарч буйг Түрүүлж мэдсэн үед**

**1 Утаа гарах эсвэл гал гарахыг түрүүлж харсан үед**

- Гал гархыг харсан үед "Гал гарлаа" гэж чанга дуугаар хашгираад аваарын дохиог дарна.




**2 Галыг унтраах эсвэл хурдан дүрвэх шаардлагатай эсэхээ шийднэ.**


- Хэрэв таазанд хүрээгүй бага зэрэг гал гарч байвал галын хор юмуу хувинтай усаар хурдан унтраана.
- Гал маш ихээр гарч эхэлвэл нойтон алчуур болон бүтээлэг хэрэглэн гадагш гарах.
- Хэрэв гадагшаа гарах аргагүй тохиолдолд дундын ханаар(нимгэн ханатай) цөмлөн хөршийнхрүүгээ орох, цонхоор шилжих, мөн гэрт байдаг аюулгүй обектод ороод гал унтарсны дараа гарч ирэх зэрэг аргуул байдаг.

※ 1992оны 10сараас өмнө ашиглалтанд орсон байрнууд галын аюулын үед нүүлгэн шилжүүлэх байгууламж болон гал унтраах тоног төхөөрөмж байхгүй тохиолдол байдаг ба аюулгүй байдлын үүднээс суурилуулахыг шаардаж байгаа.


**Өндрийн бүс(олс) Хэрэглэх арга**




Хананд байгаа тогтоогчинд олсоо бэхэлнэ.



Тогтоогчоо цонхон талруугаа түлхэж олсоо гадагш шиднэ.



Бүсээ цээжээрээ зүүж чангална.



Ханад тулгуурлан доошоо аюулгүй бууна.

**Утаанаас хамгаалах Авах арга хэмжээ**



Нойтон алчуур болон хувцасаар ам хамараа халхалах.



Шалтай ойр бөхийж явах.



Нөгөө гараараа хана түшиж явах.




Нэг чиглэлд хурдан гүйж гадагш гарах.

**Гал унтраагч Галын хор ашиглах заавар**



Лацыг сугалана.



Хошууг галын голомтруу чиглүүлнэ.




Хөшүүргийг сайтар атгана.




Нунтагыг жигд цацна.

※ Гадагш гүйж гарахад бэлэн хаалгатай ойрхон байх хэрэгтэй.


**Гал унтраагч  
Галын  
хоолой  
ашиглах  
заавар**



2хүний нэг нь цоргын хайрцагыг онгойлгож шүршүүр цорго болон хоолойг шалгах.



Хоолойг орооцолдуулахгүйгээр гал гарч буй хэсэгт аваачиж дараа бэлэн болсон эсэхээ мэдэгдэнэ.




Нэг нь хавхлагыг эргүүлж ус гарч эхэлмэгц хоолойны урд хэсэгт очиж цуг барилцана.




Шүршигч цоргоос ус гарах хэмжээг тохируулан галруу усаар шүршинэ.

**Гал унтраах  
Хувцас чинь  
галд өртвөл**



Хийж байсан үйлдлээ зогсоох



Нүд, хамар, амаа хамгаалах.



Доошоо харж хэвтэх.



Галыг унтартал хөрвөөх.

※ Нүүр түлэгдэх болон утаа уушигруу нэвтэрхээс сэргийлэх.

**119  
Дуудлага  
өгөх**



**1 Энгийн утаснаас**

- 1 Утасны харилцуураа аваад
- 2 119-ийг дараалалаар нь дарна
- 3 Гал командын ажилтанд асуултанд сандралгүй хариулна.



**2 Гар утаснаас**

- 1 119рүү залгана.
- 2 Гал командын ажилтанд асуултанд сандралгүй хариулна.

[www.119.go.kr](http://www.119.go.kr)



신고하기 >

**3 Интернээтээр дуудлага хийх**

- 1 Итернэт хаягаар орох
- 2 Дуудлага хийх цонхыг дарна.
- 3 Овог нэр болох шаардлагатай мэдээлэлийг оруулах.
- 4 Ослын талаар тодорхой тэмдэглэх.
- 5 Дуудлага бүртгэгдсэн эсэхийг шалгах.




**4 Нийтийн утаснаас**

- 1 Утасны харилцуураа аваад
- 2 Яаралтай(улаан өнгийн) товчлуурыг дарна.
- 3 119-ийг дараалалаар нь дарна
- 4 Гал командын ажилтанд асуултанд сандралгүй хариулна.

**Tip!**

**ний эргэн тойронд намайг хамгаалж байдаг галын хэрэгсэлүүд**



Агааржуулалтын тоног төхөөрөмж, гал илрүүлэгч, шүршигч, автомат гал унтраагч гэх мэт.